

# САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2009 оны 09 дүгээр  
сарын 23-ны өдөр

Дугаар 246

Улаанбаатар хот

Г Хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор Г  
батлагдсан журамд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6.1.2, 6.2.1, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 13.4, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 475/182 дугаар тушаалаар баталсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын 1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Санхүүгийн зохицуулах хорооноос ТОГТООХ нь:

1. Санхүүгийн зохицуулах хорооны 2008 оны 191 дүгээр тогтоолоор батлагдсан “Банк бус санхүүгийн үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журам”-ын 4.4 дэх заалтын “ББСБ нь зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2004 оны 9 дүгээр сарын 09-ний өдрийн 459/207 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”, Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2006 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 147/94 тоот тушаалаар журамд оруулсан нэмэлт өөрчлөлтийн дагуу тооцож байгуулна” гэснийг “ББСБ нь зээл, үнэт цаас, хүлээж болзошгүй үүрэг, бусад активын эрсдэлийн санг Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын хамтарсан 2010 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн 475/182 дугаар тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу тооцож байгуулна” гэж өөрчилсүгэй.

2. Журамд өөрчлөлтийг оруулж олон нийгэд мэдээлэхийг Тамгын газар /Н.Удаанжаргал/-г даалгасугай.

3. Энэхүү журмын өөрчлөлтийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллахыг Банк бус санхүүгийн байгууллагын хувь нийлүүлэгчид, Төлөөлөн удирдах зөвлөл, Гүйцэтгэх захирал нарт үүрэг болгосугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН